



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 11/375

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн /а/, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.10, 4.5.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын 2-р багийн нутаг "Цагаан хошуу" газар гарсан малын гоц халдварт Шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхжаргал - Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Я.Алтанхундага - Онцгой байдлын газрын дарга
Б.Очирдорж - Цагдаагийн газрын дарга
Б.Алтантөгс - Зооноз өвчин судлалын төвийн дарга
Е.Отгонцэцэг - Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
Ц.Гэрэл - Халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн
Д.Эрдэнэцэцэг - Мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
Д.Загдсүрэн - Гурвансайхан сумын Засаг дарга
И.Эрдэнэбилэг - Өлзийт сумын Засаг дарга
Р. Мөнхтогтох - Сайнцагаан сумын Засаг дарга
Л.Цогзолмаа - Луус сумын Засаг дарга
Л.Мөнхбадрах - Өндөршил сумын Засаг дарга
Ч.Зоригтбаатар - Хулд сумын Засаг дарга

Хоёр. Малын гоц халдварт шүлхий өвчний талаарх мэдээллийг тогтмол авч, сахилга дэг журам сахиулан, удирдлага зохион байгуулалтаар хангаж шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн

000000573

газар /Б.Мөнхжаргал/, Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Онцгой байдлын газар /Я.Алтанхундага/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Малын гоц халдварт шүлхий өвчний үед ажиллах дэглэм журмын дагуу сумын дэвсгэр нутагтаа холдбогдох арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулахыг Гурвансайхан, Өлзийт сум түүний хил залгаа орших Өндөршил, Хулд, Луус, Сайнцагаан, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Шүлхий өвчний голомтийг тархаахгүй хорио тогтоох, эрүүл малыг вакцинжуулах, өвчилсөн болон өвчнөөр хорогдсон малын сэг зэмийг устгах ажлыг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шуурхай зохион байгуулж, ажлын явц байдлын талаар аймгийн Онцгой байдлын газарт тогтмол мэдээлж байхыг ажлын хэсгийн ахлагч /Б.Мөнхжаргал/-д, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ж.МӨНХЧУЛУУН

